

ЭСВАТИНИЙН ХААНТ УЛСЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нутаг дэвсгэр	17,364 км ²
Хүн ам	1,236,126 (2023 он)
Албан ёсны хэл	Свази, англи
Шашин	89.3% христ, 7.4% шашин шүтдэггүй, 2.5% уламжлалт шүтлэгтэй, 0.8% бусад
Нийслэл	Мбабане (хүн ам. 94,874), Лобамба (хүн ам. 9,900)
Засаг захиргааны нэгж:	4 бүс нутаг, 55 тинкундла
Улс төрийн тогтолцоо	
Засаглалын хэлбэр	Хэмжээлшгүй эрхт хаант засаглал
Хаан	Мсвати III /Mswati III/ 1986 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс
Ерөнхий сайд	Рассел Дламини /Russell Dlamini/ 2023 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс
Гадаад харилцааны сайд	Фолил Шаканту /Pholile Shakantu/
Хууль тогтоох засаглал	Парламент
Эдийн засгийн үзүүлэлтүүд	
Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/	13 тэрбум \$ (2024 он)
Эдийн засгийн өсөлт	4.2% (2024 он)
Нэг хүнд ноогдох ДНБ	3,775 \$ (2024 он)
Инфляцийн түвшин	4.76% (2024 он)
Гадаад худалдаа	Экспортын хэмжээ 2.07 тэрбум ам.доллар: косметик, элсэн чихэр, химийн бүтээгдэхүүн, мод, ундаа, үйлдвэрийн тоног төхөөрөмж Импортын хэмжээ 2.12 тэрбум ам.доллар: газрын тос, ашигт малтмалын түлш, үйлдвэрийн тоног төхөөрөмж, моторт хөдөлгүүрүүд, сэлбэг, хуванцар, хөвөн, үр тариа, эм, эмийн бүтээгдэхүүн
Байгалийн баялаг	Нүүрс, шавар, касситерит, ой мод, алт, очир алмаз, тальк
Эдийн засгийн гол салбарууд	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, аялал жуучлал, мал аж ахуй, нэхмэл бэлэн хувцас

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Эсватинийн Хаант Улстай
дипломат харилцаа тогтоох тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэслэн НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох асуудлыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурах зөвшөөрөл олгосон.

Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурсны дараа дипломат харилцаа тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг гарын үсэг зурсан дарааллаар нь улс тус бүрээр боловсруулж, УИХ-д багцлан өргөн мэдүүлэхийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дээрх хуралдаанаас мөн даалгасан.

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дээрх шийдвэрийн дагуу Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурсан.

Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулснаар тус улстай дипломат харилцаа тогтоох манай улсын дотоодын процедур гүйцэлдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР